



МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

Хуульд заасан шаардлага: Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн нь банк, санхүү, эдийн засаг, хууль зүйн чиглэлээр мэргэшсэн, эдгээр салбарын ажлын дадлага туршлагатай, ёс зүйн хувьд төлөвшсөн, дараахь шаардлагыг хангасан хүн байна:

1/ Монгол Улсын 30-аас дээш насны иргэн, ял шийтгэлгүй;

2/ банк, санхүү, эдийн засаг, хууль зүйн мэргэжлээр магистрын болон түүнээс дээш зэрэг, цолтой.

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэг:

5.Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр банк, санхүү, эдийн засгийн салбарын асуудал хариуцсан төрийн байгууллагад өмнө нь ажиллаж байсан хүнийг томилж болно.

6.Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, төрийн улс төрийн бусад албан тушаалтан, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, төрийн захиргааны албан тушаалтан, Монголбанкны удирдах албан тушаалтныг томилж үл болно.

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1.1	<p>Эцэг/эхийн нэр: Нинжбат Ургийн овог: Хиад боржигон Нэр: Ууганбаатар Хүйс: Эр Төрсөн он: 1982 Төрсөн газар: Арвайхээр Иргэний харьяалал: Монгол Улс Одоо оршин суугаа аймаг /нийслэл, сум/ дүүрэг: Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 27-р хороо.</p>						
1.2	<p>Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА</p>						
1.3	<p>Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн эсэх <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Үгүй бол Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэхийг тодорхой бичих/</i> Тийм</p>						
1.4	<p>Боловсрол</p> <ul style="list-style-type: none"> • Стокхольмын эдийн засгийн сургууль, Эдийн засгийн ухааны доктор /PhD/. 2008-2012. Стокхольм, Шведийн Вант Улс. • Дээд судлалын институт, Эдийн засгийн ахисан түвшний хөтөлбөр, 2006-2008. Вена хот, Бүгд Найрамдах Австри Улс. • Төсвийн санхүүгийн бакалавр, Докуз Эелүл Их Сургууль, 2001-2005. Измир хот, Бүгд Найрамдах Турк Улс. 						
1.5	<p>Боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг Эдийн засгийн ухааны доктор /PhD/</p>						
1.6	<p>Эрүүл мэнд Сэтгэцийн өвчин, эмгэгтэй эсэхийг тодорхойлсон нотлох баримтыг жагсааж, хавсаргана.</p> <p>Эрүүл</p>						
1.7	<p>Эрхэлсэн ажил Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Эдийн засаг, банк, санхүү, эрх зүйн аль нэг чиглэлээр эзэмшсэн мэргэжлээрээ ажилласан туршлагатай, удирдлагын мэдлэг, мэргэшлийн ур чадвартай болохыг нотлох баримтыг хавсаргана. Ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse; margin-top: 10px;"> <thead> <tr> <th style="width: 40%;">Эрхэлсэн ажил /Бүтэн цагаар/</th> <th style="width: 20%;">Огноо</th> <th style="width: 40%;">Байгууллага</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн</td> <td>2024 оны 1 сараас...</td> <td>Улсын Их Хурал</td> </tr> </tbody> </table>	Эрхэлсэн ажил /Бүтэн цагаар/	Огноо	Байгууллага	Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн	2024 оны 1 сараас...	Улсын Их Хурал
Эрхэлсэн ажил /Бүтэн цагаар/	Огноо	Байгууллага					
Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн	2024 оны 1 сараас...	Улсын Их Хурал					

	Багш, Дэд, Проф.	2021 оны 1 сараас 2024 оны 9 сар.	МУИС-ийн Эдийн Засгийн тэнхим
	Багш, Дэд, Проф.	2012 оны 09 сараас 2021 оны 1 сар.	МУИС-ийн Математикийн тэнхим
	Эрхэлсэн ажил /Гэрээт/	Огноо	Байгууллага
	Дэд, Проф.	2024 оны 9 сараас.	МУИС-ийн Эдийн Засгийн тэнхим
	Гэрээт зөвлөх	2023 он	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар
	Гэрээт зөвлөх	2021 он	Дэлхийн Банк
	Эрдэм шинжилгээний ажилтан	2019 он	ШУА, Математик, тоон технологийн хүрээлэн
1.8	Ашиг сонирхлын зөрчил Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшдэг, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг эсэх, Банк бус санхүүгийн байгууллага, банкны хувьцаа эзэмшдэг эсэхийг бичих. <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар хувьцаа, аж ахуйн үйл ажиллагааг ямар хугацаанд эзэмшиж, эрхэлж байгаа, эсхүл эзэмшиж, эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/</i> <ul style="list-style-type: none"> • Эрдэнэс таван толгой ХК-д 1072 хувьцаа эзэмшдэг. • Аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэггүй; • Банк бус санхүүгийн байгууллага, банкны хувьцаа эзэмшдэггүй. 		
1.9	Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэхийг бичих. <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</i> Үгүй		
1.10	Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар Сүүлийн таван жил ямар мэргэжлийн холбоо, байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан, гишүүнчлэлийн талаар бичих. <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаал, чиг үүрэг гүйцэтгэж байсан талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/</i> Үгүй		
1.11	Мэргэжлийн ёс зүйн талаар Мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргаж байсан эсэх. <i>/тийм эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</i> Үгүй		

1.12 Хэрэв доор дурдсан мэдээлэл нэр дэвшигчид байгаа бол

-Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.

Чиглэл	Хэлбэр	Өгүүллийн Тоо	Сэтгүүлийн нэр
Эдийн засаг; Олны сонголтын онол, Шийдвэрийн онол	Олон улсын сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл	9	Economic Theory Bulletin, SERIEs, Hitotsubashi J. Econ, Econ. Letters, Czech Econ. Review, Economic Bulletin, Finnish Econ Papers, Social Choice and Welfare.
Математик; Дискрет Геометр, Геометр оптимизаци, Графын онол.	Олон улсын сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл	6	Elemente der Mathematik, The Math. Intelligencer, Resonance: Journal of Science Education, Forum Geometricorum, The American Math. Monthly, Arnold Math. Journal
Эдийн засаг, Төрийн удирдлага, Статистик, Боловсрол судлал, Математик	Дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл	12	Үндэсний Статистик Сэтгүүл, Төрийн удирдлага : Онол, арга зүйн сэтгүүл, Парламентын Судалгаа Шинжилгээ, Эдийн засаг: Онол, практик, Музей Судлал, Боловсрол Судлал

Дээрх 27 судалгааны өгүүлэлтэй <https://sites.google.com/site/uugnaaninibat/> сайтаар дамжин танилцаж болно.

-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.

Байгууллагын нэр, хаяг	Огноо	Гол агуулга
Төсвийн тогтвортой байдлын зөвлөл	2024.03.15	МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ТӨЛӨВ БАЙДЛЫН ТААМАГЛАЛЫН ТАЙЛАН
Төсвийн тогтвортой байдлын зөвлөл	2024.05.13	МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ
Төсвийн тогтвортой байдлын зөвлөл	2024.05.20	МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛД ӨГСӨН ТӨСВИЙН

		ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ
Төсвийн тогтвортой байдлын зөвлөл	2024.08.28	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ӨГСӨН ДҮГНЭЛТ
Төсвийн тогтвортой байдлын зөвлөл	2024.09.20	Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөлөөс өгсөн дүгнэлт

Дээрх тайлангуудтай <https://www.parliament.mn/nc/1713/> сайтаас танилцаж болно.

-Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.

Илтгэл	Огноо	Газар
Кант ба Метафизик	2024.11 сар	Социал Демократ Монголын Залуучуудын Холбоо
Эрдэмтний нүдээр ПИСА	2024.09 сар	БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
Монгол Энэтхэгийн харилцааны эдийн засгийн потенциал	2024. 05 сар	“Газрын Тос – 2024” ЭШ Хурал, ШУТИС
Адам Смит ба Соён Гэгээрэл	2023. 12 сар	Дэвшилтэт Бодлогын Хүрээлэн
Татвар ашиг тусын шинжилгээнд микро симуляци ашиглах нь: МОНТАТ загвар	2023. 12 сар	УИХ-ын Дарга, гишүүд болон бусад холбогдох албан тушаалтнууд
Татварын цуврал лекцууд	2022-2023 он.	Youtube.com

-Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.

Ярилцлага, нийтлэл	Огноо	Эх сурвалж
2025 оны төсвийн тухай	2024.11 сар	Цагийн Хүрд, МҮОНТ
Дунд хугацааны макро эдийн засгийн төлөв байдал.	2024.10 сар	Тоон тойм, EAGLE TV
Төсөв болон ирэх оны макро эдийн засаг.	2024.09 сар	News.mn
Олон тооны нийтлэлүүд	2019-2024	https://gogo.mn/p/9452
Шинжлэх ухаан гэж юу вэ?	2023 он	Gej Yu Ve
УИХ-ын гишүүдийн тоо, холимог системийн учир.	2023 он	Sonin.mn

/Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана/

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ. <i>/500-1000 үгэнд багтаана/.</i></p> <p>Сүүлийн нэг жилийн хугацаанд Монголбанк дээр түр байрлахын зэрэгцээ,</p> <ul style="list-style-type: none">• 2024 оны 2 сард Монголбанкны нэр бүхий ажилтантай Макро эдийн засгийн төсөөлөл боловсруулахад ашиглах загварын талаар дэлгэрэнгүй санал солилцсон,• 2024 оны 3 сард Монголбанкны удирдлагуудтай албан уулзалт хийсэн,• 2024 оны 8 сард Монголбанкны 100 жилийг тэмдэглэх хүрээнд зохион байгуулагдсан олон улсын эрдэм шинжилгээний хуралд суусан,• 2024 оны 9 сард намар ОУВС-аас зохион явуулсан Санхүүгийн програмчлалын сургалтад хамрагдахад Монголбанкны төлөөлөл, ажилтнуудтай яриа өрнүүлэх боломж гарсан <p>зэргээр энэ байгууллагыг илүү сайн таних боломж гарсан юм.</p> <p>Мөн Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй Дэлхийн Банк, ОУВС, АХБ зэрэг олон улсын байгууллагуудаар зочилж, ажил хэргийн уулзалт явуулсны дээр “Төрөөс 2025 онд баримтлах мөнгөний бодлогын чиглэл”-ийн хэлэлцүүлгийг ойроос сонирхон үзэх зэргээр тус байгууллага нь институцын хувьд хөгжлийн аль түвшинд явааг эхний байдлаар тодорхойлох боломж бүдрсэн юм. Учир нь дотоод зохион байгуулалт, байгууллагын соёл, атмосфер, удирдах албан тушаалтнууд, захирлуудын зөвлөлийн зарим гишүүдээс эхлэн шинэхэн ажиллаж буй залуучууд, мэргэжилтнүүд гээд олон өөр шатны боловсон хүчинтэй тодорхой сэдвээр санал солилцсоны дээр УИХ, Санхүүгийн Зохицуулах Хороо зэрэг дотоодын байгууллагуудтай, мөн дээр нэр дурдсан олон улсын байгууллагуудтай тус байгууллага хэрхэн харилцаанд ордог болохыг тодорхой түвшинд ойроос ажигласан хэрэг.</p> <p>Судлаач хүний хувиар анзаарсан зарим зүйл/таамаг гэвэл</p> <ul style="list-style-type: none">- Тус байгууллага харьцангуй хаалттай; Энэ нь харуул манаанаас эхлээд хуулиар олгогдсон зарим хязраарлалт, хамгаалалтаас ил харагдана. УИХ-ын зарим гишүүд Монголбанкны хяналт шалгалтын дүнг ил болгох буюу тус байгууллагыг санхүүгийн хувьд илүү ил тод байлгах талаар ярьдаг бол хэвлэл мэдээллээр зарим нотлогдохгүй хэр нь няцаагдахгүй хөрөнгө, мөнгөтэй холбоотой мэдээнүүд цацагдах явдал гардаг. Тодорхой хэмжээнд мэдээллийн хувьд хаалттай буюу хамгаалалттай байх нь оновчтой гэдгийг төв банкны түүх бидэнд харуулдаг. Учир нь спекулатив дайралт хамгийн олон жилийн түүхтэй
------------	---

төв банкнийг хүртэл сандаргах боломжтойг 1992 оны Их Британийн төв банкны кэйс бидэнд сануулдаг (хар Лхагва гараг).

- Төв банкны хараат бус байдал: Дээр дурдсан 100 жилийн ойн хүрээнд зохиогдсон хурлын гол сэдэв нь хараат бус төв банк байв. Сонирхолтой нь бие даасан (independent) байх уу, харилцан хамааралтай (interdependent) байх уу? гэдэг нарийн асуудал төдийлөн хөндөгдөөгүй, сонголтыг шууд эхнийхээр нь хийсэн байв. Гэтэл практик дээр энэ сонголт хар эсвэл цагаан гэсэн сонголт биш юм. Үүний хамгийн том жишээ нь валютын ханшийн бодлогыг хэрхэн хэрэгжүүлж байгаагаас харагдана. Тухайлбал бид “инфляцыг онилох, хөвөгч валютын ханштай байх, капиталын урсгалыг чөлөөтэй орхих” бодлогын сонголт хийсэн ч, валютын нөөц нь мөнгөний нийлүүлэлттэй эн тэнцүү чухал үзүүлэлт болж, хэрэгцээ гарвал хөвөгч ханш дээр ч интервенц хийсээр ирсний дээр импортын хараат байдал нь инфляц болон ханшийн хооронд хүчтэй хамаарлыг бий болгосоор байна. Үүн дээр ипотекийн хөнгөлөлттэй зээл болон ижил төстэй, тодорхой бүлэг, салбарын хөгжлийг онилсон мөнгө, санхүүгийн хөтөлбөрүүд Монголбанкаар дамжин хэрэгждэг. Иймд де факто Монголбанк нь ‘харилцан хамааралтай’ институц болж хөгжсөн гэсэн дүгнэлт хийж болохоор юм.
- Эрдэм шинжилгээ, судалгаа: Эрдэм шинжилгээ, судалгаанд харьцангуй анхаарч ирсэн. Цаашид одоогийн байгаа түвшнийг ахиулах чиглэлд илүү их ажиллах шаардлагатай. Тухайлбал эдийн засгийн загвар боловсруулахдаа Монгол улсын онцлогийг хангалттай тусгаж чадаж байгаа эсэх?, загварын үр дүнг бодлого боловсруулахад зохистой бөгөөд хангалттай ашиглаж чадаж байгаа эсэх зэрэг нарийн асуудлууд орхигдож байгаа нь анзаарагддаг. Мөн дээрх хаалттай байдлаар улбаалан тус банкны судалгаа нь нэг чигт, тодорхой хүрээнд төвлөрсөн, хязгаарлалттай хүрээнд байна. Гэтэл тэдэнд байгаа мэдээлэл төдийлөн бусад судлаачдад нээлттэй биш байна. Энэ нь үр ашиггүй байдал үүсгэж байгаа буюу мэдээлэлд хүрэх боломжтой хэр нь чиг үүргийн дагуу биш сэдвээр судалгаа хийгдэхгүй, тийм судалгаа хийх сонирхолтойд нь мэдээлэл олдохгүй нөхцөл байдалд хүргэдэг.
- Бодлогын чиглэл: Тогтворжуулах уу, тэлэх үү? гэсэн өгөө аваан дээр тогтдог нь нууц биш. Энэ өгөө аваа Кодивын жилүүдэд маш тодорхой харагдсан. Бодлогын хүүг 6% хүртэл бууруулаад араас нь богино хугацаанд 13% хүртэл өсгөсөн. Огцом буурсан бодлогын хүү болон бусад арга хэмжээнүүд огцом инфляц дагуулсан. Харин огцом өссөн хүү, инфляцыг аажим бууруулсан.
- Хүлээн зөвшөөрөгдсөн байдал: Монголбанк нь олон улсын байгууллагуудын түвшинд харьцангуй сайн нэр хүндтэй буюу үүргээ боломжийн биелүүлдэг гэсэн үнэлгээтэй болохыг тэдний авсан зарим шагналууд харуулдаг. Энэ нь мэдээж хэрэг сайн зүйл мөн. Харин дотоодоо буюу ард иргэд, хэвлэл мэдээлэл дунд тодорхой хардалт дагуулдаг. Энэ нь баримталж буй мөнгөний бодлого гэхээсээ хагас хаалттай байдлаас үүдэлтэй батлагдахгүй хэр нь няцаагдахгүй байгаа мэдээллүүдээс үүдэлтэй хэрэг. Цаашид дотоод нэр хүндийг өсгөх тал дээр тодорхой арга хэмжээнүүд авагдах нь зөв.

Би хэрэв сонгогдвол дээрх таван чиглэл болон УИХ-аас өгөгдсөн чиглэлийн дагуу идэвх санаачилгатай ажиллаж, асуудалд шинжлэх ухаанч байдлаар хандах болно. "Хаа нарны гэрэл тусдаггүй бол тэнд их эмч шагайх хэрэгтэй" гэсэн мэргэн үг бий.